



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/252

Ховд

Санхүүжилт хуваарилах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хянан баталгаажуулах түр журам”-ын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон санхүүжилт болох 34,479,000 төгрөгийг сумдад 2020 оны жилийн эцсийн татварын гүйцэтгэлийг үндэслэн хуваарилж, хавсралтаар батлан шилжүүлсүгэй.

2. “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хянан баталгаажуулах түр журам”-ын дагуу олгох санхүүжилт болох 34,479,000 төгрөг (гучин дөрвөн сая дөрвөн зуун далан ёсөн мянга)-ийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн санхүүжилтээс санхүүжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Уг санхүүжилтийг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.1, 41.9.2-д заасны дагуу зарцуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.



ДАРГА Б. ДҮГЭРЖАВ

8400 01 1237



Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 2 ны өдрийн
А/252 дугаар захирамжийн
хавсралт

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХУРААМЖИЙГ СУМДАД ОЛГОХ ЖАГСААЛТ

Д/д	Сумын нэр	2021 оны 4,5,6,7,8,9 дүгээр саруудын санхүүжилт
1	Алтай	783,393
2	Булган	-
3	Буянт	2,823,107
4	Дарви	1,188,805
5	Дуут	1,313,553
6	Дөргөн	385,080
7	Зэрэг	1,203,746
8	Манхан	1,200,340
9	Мянгад	1,206,108
10	Мөст	1,442,031
11	Мөнххайрхан	3,319,759
12	Үенч	1,517,888
13	Ховд	160,655
14	Цэцэг	6,795,714
15	Чандмань	251,793
16	Эрдэнэбүрэн	1,452,589
17	Жаргалант	9,434,438
	Нийт	34,479,000

-оОо-